**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

# Баянхонгор аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2023/106/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn
Баянхонгор хот
2023.02.17


Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цээням
Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn
Аудитор: Б.Нарангэрэл
Утас: 99009293 Цахим хаяг: Narangerelb@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ........ 3
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ........ 5
**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ........ 11
**4. АУДИТЫН ТАЙЛАН** ........ 13
**4.1 Ерөнхий зүйл** ........ 13
**4.2 Материаллаг байдал** ........ 14
**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** ........ 14
**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** ........ 14
**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ........ 15
**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ........ 15
**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал** ........ 15
**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ........ 15
**5.1 Төлбөрийн акт** ........ 16
**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ........ 16

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ШШГГ | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсандандзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2023.02.15 № 2/16

танай ______ -ны №______ -т

БАЯНХОНГОР АЙМГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗРЫН ДАРГА, ХУРАНДАА П.НАРАНБААТАР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө,өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 43 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 81.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн

D- alban bichig 2022 A4 ТООТ

005020147

төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

D- alban bichig 2022 A4 ТООТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

# 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **71,788,243.98** | **69,563,563.55** |
| **33** | **АВЛАГА** | **270** | **0** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 270 | 0 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **71,787,973.98** | **69,563,563.55** |
| **35100** | **Түүхий эд материал** | **26,969,613.00** | **26,898,693.00** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 26,671,663.00 | 26,263,243.00 |
| 35130 | Эм боох материал | 297,950.00 | 635,450.00 |
| 35200 | Дуусаагүй үйлдвэрлэл | 0 | 6,431,500.00 |
| **35400** | **Хангамжийн материал** | **44,818,360.98** | **36,233,370.55** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,655,350.00 | 2,540,460.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 22,843,025.00 | 21,921,491.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 93,000.00 | 150,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 545,000.00 | 20,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 7,435,000.00 | 0 |
| 35460 | Хүнсний материал | 334,019.98 | 1,253,925.55 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 11,912,966.00 | 10,347,494.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,217,312,443.82** | **1,442,711,025.37** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,217,312,443.82** | **1,442,711,025.37** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **1,095,232,710.52** | **1,046,924,292.11** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,127,586,711.54 | 1,127,586,711.54 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -173,378,938.04 | -215,600,086.64 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 147,813,725.00 | 127,833,333.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -111,758,169.92 | -102,083,333.52 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 145,988,375.65 | 155,798,210.90 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -80,233,193.37 | -83,561,122.06 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 81,995,356.00 | 88,479,754.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -47,566,304.34 | -56,314,323.11 |
| 39211 | Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж | 4,715,148.00 | 4,715,148.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 70,000.00 | 70,000.00 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **122,079,733.30** | **395,786,733.26** |
| 39301 | Програм хангамж | 6,417,692.31 | 6,417,692.31 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -2,159,359.01 | -3,181,359.05 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 117,821,400.00 | 392,550,400.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,289,100,687.80** | **1,512,274,588.92** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,289,100,687.80** | **1,512,274,588.92** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **1,289,100,687.80** | **1,512,274,588.92** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 221,624,669.45 | 221,624,669.45 |
| 511001 | Улсын төсвийн оруулсан хөрөнгө | 221,624,669.45 | 221,624,669.45 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **636,445,907.88** | **859,619,809.00** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 633,728,560.56 | 636,445,907.88 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 2,717,347.32 | 223,173,901.12 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 431,030,110.47 | 431,030,110.47 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,289,100,687.80** | **1,512,274,588.92** |

/төгрөгөөр/

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **713,854,387.00** | **955,687,623.01** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **56,062,787.00** | **305,796,423.01** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **56,062,787.00** | **305,796,423.01** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **6,328,610.00** | **274,969,000.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 0 | 82,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 210,000.00 | 158,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 6,118,610.00 | 274,729,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 27,693,000.00 | 23,178,133.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 22,041,177.00 | 7,649,290.01 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **657,791,600.00** | **649,891,200.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **634,551,600.00** | **649,891,200.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 634,551,600.00 | 649,891,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **23,240,000.00** | **0** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 22,800,000.00 | 0 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 440,000.00 | 0 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **711,137,039.68** | **732,513,721.89** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **711,137,039.68** | **732,513,721.89** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **708,664,340.25** | **728,500,037.23** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **461,781,597.91** | **462,813,380.79** |
| 210101 | Үндсэн цалин | 303,751,437.91 | 304,013,845.96 |
| 210102 | Нэмэгдэл | 155,091,900.00 | 139,259,995.13 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,938,260.00 | 12,520,000.00 |
| 210104 | Урамшуулал | 0 | 7,019,539.70 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **10,274,454.16** | **9,399,866.12** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 738,059.36 | 46,248.64 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 86,827.50 | 5,441.02 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 111,333.76 | 4,352.81 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 17,366.11 | 1,088.20 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,320,867.43 | 9,342,735.45 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **82,334,014.95** | **86,451,100.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 12,075,522.95 | 11,487,273.00 |
| 210302 | Түлш, халаалт | 61,790,000.00 | 66,025,025.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8,468,492.00 | 8,938,802.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **16,567,432.55** | **25,684,550.43** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,504,510.00 | 3,007,210.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,920,000.00 | 16,086,427.13 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,585,922.55 | 2,605,399.30 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 450,000.00 | 550,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,107,000.00 | 1,006,000.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 0 | 2,429,514.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **44,621,356.48** | **34,845,476.43** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,136,450.00 | 827,900.00 |
| 210502 | Хоол, хүнс | 41,901,058.48 | 33,668,294.43 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 583,848.00 | 349,282.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **3,378,256.00** | **16,377,300.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0 | 32,600.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 0 | 170,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,378,256.00 | 16,174,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **0** | **762,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 0 | 762,000.00 |

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **10,025,935.00** | **5,508,612.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,639,900.00 | 3,697,100.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 300,000.00 | 300,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 612,956.00 | 380,312.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 88,000.00 | 110,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,147,139.00 | 554,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 237,940.00 | 466,700.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **79,681,293.20** | **86,657,751.46** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 404,600.00 | 4,854,000.01 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 259,800.00 | 100,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 79,016,893.20 | 81,703,751.45 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,472,699.43** | **4,013,684.66** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **252,000.00** | **0** |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 252,000.00 | 0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **1,989,000.00** | **3,392,500.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,989,000.00 | 3,392,500.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **231,699.43** | **621,184.66** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 231,699.43 | 621,184.66 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **2,717,347.32** | **223,173,901.12** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **2,717,347.32** | **223,173,901.12** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **659,177,600.00** | **650,131,200.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,386,000.00** | **240,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **1,386,000.00** | **240,000.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **210,000.00** | **240,000.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 0 | 82,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 210,000.00 | 158,000.00 |
| 120009 | Бусад орлого | 1,176,000.00 | 0 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **657,791,600.00** | **649,891,200.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **634,551,600.00** | **649,891,200.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 634,551,600.00 | 649,891,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **23,240,000.00** | **0** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 22,800,000.00 | 0 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 440,000.00 | 0 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **636,527,600.00** | **640,936,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **636,527,600.00** | **640,936,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **634,054,900.57** | **636,922,315.34** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **462,957,597.91** | **462,813,380.79** |
| 210101 | Үндсэн цалин | 304,927,437.91 | 304,013,845.96 |
| 210102 | Нэмэгдэл | 155,091,900.00 | 139,259,995.13 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,938,260.00 | 12,520,000.00 |
| 210104 | Урамшуулал | 0 | 7,019,539.70 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **10,274,724.16** | **9,399,596.12** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 738,059.36 | 46,248.64 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 86,827.50 | 5,441.02 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 111,333.76 | 4,352.81 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 17,366.11 | 1,088.20 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,321,137.43 | 9,342,465.45 |

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **82,334,014.95** | **86,451,100.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 12,075,522.95 | 11,487,273.00 |
| 210302 | Түлш, халаалт | 61,790,000.00 | 66,025,025.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8,468,492.00 | 8,938,802.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **15,691,072.55** | **22,400,326.43** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,917,250.00 | 2,704,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,520,000.00 | 15,561,427.13 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,585,922.55 | 2,605,399.30 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 450,000.00 | 550,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,217,900.00 | 978,600.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **39,812,000.00** | **35,408,100.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,018,200.00 | 819,900.00 |
| 210502 | Хоол, хүнс | 38,793,800.00 | 34,588,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **11,133,256.00** | **11,254,700.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0 | 32,600.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 320,000.00 | 170,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 10,813,256.00 | 11,052,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **0** | **762,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 0 | 762,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **10,465,935.00** | **5,508,612.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,079,900.00 | 3,697,100.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 300,000.00 | 300,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 612,956.00 | 380,312.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 88,000.00 | 110,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,147,139.00 | 554,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 237,940.00 | 466,700.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,386,300.00** | **2,924,500.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,126,500.00 | 2,824,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 259,800.00 | 100,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,472,699.43** | **4,013,684.66** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **252,000.00** | **0** |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 252,000.00 | 0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **1,989,000.00** | **3,392,500.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,989,000.00 | 3,392,500.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **231,699.43** | **621,184.66** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 231,699.43 | 621,184.66 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **22,650,000.00** | **9,195,200.00** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **22,650,000.00** | **9,195,200.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **22,650,000.00** | **9,195,200.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **22,650,000.00** | **9,195,200.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 22,650,000.00 | 9,195,200.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-22,650,000.00** | **-9,195,200.00** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 | 0 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0 | 0 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **221,624,669.45** | **431,030,110.47** | **633,728,560.56** | **1,286,383,340.48** |
| **2** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **221,624,669.45** | **431,030,110.47** | **633,728,560.56** | **1,286,383,340.48** |
| **3** | **Тайлант үеийн үр дүн** | **0** | **0** | **2,717,347.32** | **2,717,347.32** |
| **4** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **221,624,669.45** | **431,030,110.47** | **636,445,907.88** | **1,289,100,687.80** |
| **5** | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **221,624,669.45** | **431,030,110.47** | **636,445,907.88** | **1,289,100,687.80** |
| **6** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **221,624,669.45** | **431,030,110.47** | **636,445,907.88** | **1,289,100,687.80** |
| 7 | Тайлант үеийн үр дүн | 0 | 0 | 223,173,901.12 | 223,173,901.12 |
| **8** | **2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **221,624,669.45** | **431,030,110.47** | **859,619,809.00** | **1,512,274,588.92** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **650,156,200.00** | **649,510,015.34** | **646,184.66** | **99.9** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **650,156,200.00** | **649,510,015.34** | **646,184.66** | **99.9** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **646,763,200.00** | **646,117,515.34** | **645,684.66** | **99.9** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **462,878,300.00** | **462,813,380.79** | **64,919.21** | **100.0** |
| 210101 | Үндсэн цалин | 320,262,000.00 | 304,013,845.96 | 16,248,154.04 | 94.9 |
| 210102 | Нэмэгдэл | 139,760,300.00 | 139,259,995.13 | 500,304.87 | 99.6 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,224,000.00 | 12,520,000.00 | -11,296,000.00 | 1022.9 |
| 210104 | Урамшуулал | 1,632,000.00 | 7,019,539.70 | -5,387,539.70 | 430.1 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **9,954,400.00** | **9,399,596.12** | **554,803.88** | **94.4** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 0 | 46,248.64 | -46,248.64 | |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 0 | 5,441.02 | -5,441.02 | |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 0 | 4,352.81 | -4,352.81 | |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 0 | 1,088.20 | -1,088.20 | |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,954,400.00 | 9,342,465.45 | 611,934.55 | 93.9 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **86,451,100.00** | **86,451,100.00** | **0.00** | **100.0** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,492,600.00 | 11,487,273.00 | 5,327.00 | 100.0 |
| 210302 | Түлш, халаалт | 66,280,900.00 | 66,025,025.00 | 255,875.00 | 99.6 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8,677,600.00 | 8,938,802.00 | -261,202.00 | 103.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **22,400,600.00** | **22,400,326.43** | **273.57** | **100.0** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,512,700.00 | 2,704,900.00 | -192,200.00 | 107.6 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15,632,700.00 | 15,561,427.13 | 71,272.87 | 99.5 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,676,600.00 | 2,605,399.30 | 71,200.70 | 97.3 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 600,000.00 | 550,000.00 | 50,000.00 | 91.7 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 978,600.00 | 978,600.00 | 0.00 | 100.0 |
| **2105** | **Нормативт зардал** | **35,408,100.00** | **35,408,100.00** | **0.00** | **100.0** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 819,900.00 | 819,900.00 | 0.00 | 100.0 |
| 210502 | Хоол, хүнс | 34,588,200.00 | 34,588,200.00 | 0.00 | 100.0 |

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **20,449,900.00** | **20,449,900.00** | **0.00** | **100.0** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 9,227,800.00 | 9,227,800.00 | 0.00 | 100.0 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 170,000.00 | 170,000.00 | 0.00 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 11,052,100.00 | 11,052,100.00 | 0.00 | 100.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **762,000.00** | **762,000.00** | **0.00** | **100.0** |
| 210702 | Дотоод албан томилолт | 762,000.00 | 762,000.00 | 0.00 | 100.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **5,508,700.00** | **5,508,612.00** | **88.00** | **100.0** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,697,100.00 | 3,697,100.00 | 0.00 | 100.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 300,000.00 | 300,000.00 | 0.00 | 100.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 380,400.00 | 380,312.00 | 88.00 | 100.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 110,000.00 | 110,000.00 | 0.00 | 100.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 554,500.00 | 554,500.00 | 0.00 | 100.0 |
| 210807 | Газрын төлбөр | 466,700.00 | 466,700.00 | 0.00 | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **2,950,100.00** | **2,924,500.00** | **25,600.00** | **99.1** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,850,100.00 | 2,824,500.00 | 25,600.00 | 99.1 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 100,000.00 | 100,000.00 | 0.00 | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **3,393,000.00** | **3,392,500.00** | **500.00** | **100.0** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **3,393,000.00** | **3,392,500.00** | **500.00** | **100.0** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,393,000.00 | 3,392,500.00 | 500.00 | 100.0 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **650,156,200.00** | **649,510,015.34** | **646,184.66** | **99.9** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **649,891,200.00** | **649,270,015.34** | **621,184.66** | **99.9** |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 649,891,200.00 | 649,270,015.34 | **621,184.66** | **99.9** |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **265,000.00** | **240,000.00** | **25,000.00** | **90.6** |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 82,000.00 | 82,000.00 | 0.00 | 100.0 |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 183,000.00 | 158,000.00 | 25,000.00 | 86.3 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь шүүхийн шийдвэрийг нэг мөр гүйцэтгэх, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дэлхий нийтээр мөрдөж байгаа эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлж, олон улсын жишигт хүргэх эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааныхаа зорилтыг дараах байдлаар тодорхойлжээ.

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийг мэргэшүүлж, алба хаах нөхцөл, аюулгүй байдал, нийгмийн баталгааг хангах
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын анги, салбар нэгжийн барилга байгууламж, ахуй нөхцөлийг олон улсын жишигт хүргэх, шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаа хэвийн явагдах материаллаг бааз суурийг бэхжүүлэх
- Баруун бүсийн Наркологийн эмнэлэг барих

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2020 оны 08 дугаар сарын 20-ны А/34 дүгээр тушаалаар баталсан " Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт

байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 223,173.9 мянган төгрөг буюу 17.3 хувиар *өссөн* байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | | Эцсийн үлдэгдэл | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|
| | Дүн | Эзлэх хувь | Дүн | Эзлэх хувь | Дүн | Хувь |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 71,788.2 | 5.6% | 69,563.6 | 4.6% | (2,224.7) | -3.1% |
| Мөнгөн хөрөнгө | - | 0.0% | - | 0.0% | - | 0.0% |
| Авлага | 0.3 | 0.0% | - | 0.0% | (0.3) | -100.0% |
| Урьдчилгаа | - | 0.0% | - | 0.0% | - | 0.0% |
| Бараа материал | 71,788.0 | 5.6% | 69,563.6 | 4.6% | (2,224.4) | -3.1% |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,217,312.4 | 94.4% | 1,442,711.0 | 95.4% | 225,398.6 | 18.5% |
| Үндсэн хөрөнгө | 1,632,408.4 | 126.6% | 1,903,451.2 | 125.9% | 271,042.8 | 16.6% |
| Хуримтлагдсан элэгдэл | (415,096.0) | -32.2% | (460,740.2) | -30.5% | (45,644.3) | 11.0% |
| **Нийт хөрөнгө** | 1,289,100.7 | 100.0% | 1,512,274.6 | 100.0% | 223,173.9 | 17.3% |
| Өр төлбөр | - | 0.0% | - | 0.0% | - | 0.0% |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,289,100.7 | 100.0% | 1,512,274.6 | 100.0% | 223,173.9 | 17.3% |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 1,289,100.7 | 100.0% | 1,512,274.6 | 100.0% | 223,173.9 | 17.3% |

Бараа материалын дансны үлдэгдэл 69,563.6 мянган төгрөг болж 2,224.4 мянган төгрөгөөр буурсан нь барилгын засварын материал данс 7,435.0 мянга, бусад хангамжийн материал данс 1,565.5 мянга, аж ахуйн материал данс 921.5 мянган төгрөгөөр буурсан нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,903,451.2 мянган төгрөг болж 271,042.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн худалдан авалтаар 9,195.2 мянга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас үнэ төлбөргүй хүлээн авсан 19,618.1 мянга, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022.09.19-ний өдрийн 393 дугаар тогтоолоор Баянхонгор аймгийн ЗДТГ-аас 3,560.0 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл, мөн тус байгууллагад аймгийн Засаг даргын 2022.11.10-ны өдрийн А/691 дугаар захирамжаар 274,729.0 мянган төгрөгийн өртөг бүхий наркологийн эмнэлгийн газрыг эзэмшүүлсэнтэй холбоотой байна.

Мөн тайлант онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022.03.17-ний өдрийн А-5/473 дугаар албан бичгээр 19,980.4 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022.06.09-ний өдрийн 291 дүгээр тогтоолоор 21 нэр төрлийн 16,079.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах шийдвэр гаргасан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,512,274.6 мянган төгрөг болж 223,173.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээр нэмэгдсэнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 722,635.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 722,635.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 72,479.6 мянган төгрөгөөр бууруулж 650,156.2 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 649,891.2 мянга, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 265.0 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 649,510.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 649,510.0 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 64.9 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 554.8 мянган төгрөгөөр зарцуулаагүй нь голлох нөлөөг үзүүлж байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | **70705 Шүүхийн шийдвэр гүйцэтгэл** | **650,156,200.00** | **649,510,015.00** | **646,185.00** | **99.9%** |
| 2 | 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал | 645,463,800.00 | 644,843,115.00 | 620,685.00 | 99.9% |
| 3 | 80102 Туслах үйл ажиллагааны зардал | 265,000.00 | 240,000.00 | 25,000.00 | 90.6% |
| 4 | 80220 Холбооны суваг ашигласны хөлс | 1,034,400.00 | 1,034,400.00 | 0.00 | 100.0% |
| 5 | 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, | 3,393,000.00 | 3,392,500.00 | 500.00 | 99.9% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй ба тус байгууллага нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер А.Цэяням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээ сарын 20-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал  711,137.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 10,667.1 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 7,466.9 мянган төгрөгөөр , тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжилтийн хүрээнд тус байгууллага нь 2022 оны бичиг хэргийн зардлыг өмнөх оноос 787.7 мянга буюу 29.1 хувиар нэмэгдүүлсэн нь ял эдлүүлэх шийдвэр гүйцэтгэх баримт бичгийн хавтасыг стандартын дагуу хийсэн мөн бичгийн цаасны үнийн өсөлтөөс шалгаалсан байна.

Харин байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг өмнөх оноос 4,117.1 мянга буюу 4.8 хувиар нэмэгдүүлсэн нь 2021 онд Ковид-19 цар тахлын үед 5 дугаар сард 15 хоногийн халаалтын авч халаалтын зардлыг хэмнэсэн мөн цэвэр бохир усны зардалд хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 49 дүгээр тогтоолоор цэвэр бохир усны үнэ тариф нэмэгдсэнтэй холбоотой байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх,

нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих хуулийн 6.4.3 “Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл”-д заасан 38,793.8 мянган төгрөгийн 1 мэдээлэл, 6.4.5 “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ”-д заасан 700,836.1 мянган төгрөгийн 19 мэдээлэл, 6.4.8 ”Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл” -д заасан 3,650.0 мянган төгрөгийн 8 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал гүйцэтгэж аудитаар 42,602.0 мянган төгрөгийн 4 зөвлөмж хүргүүлснийг бүрэн биелүүлсэн талаар тус байгууллагаас 2022.05.27-ний өдрийн 1/514 дугаартай албан бичгээр ирүүлэн, FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 0 | 0 | 0 | 0 | |
| Албан шаардлага | 0 | 0 | 0 | 0 | |
| Зөвлөмж | 4 | 42,602.0 | 4 | 42,602.0 | 100 |
| **Нийт дүн** | **4** | **42,602.0** | **4** | **42,602.0** | **100** |

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

# 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 7,070.2 мянган төгрөгийн 2 алдаа[1] илэрснээс аудитын явцад залруулав. Үүнд:

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

1. Мөнгөн хөрөнгийн харилцах данснаас 7045.2 мянган төгрөгийг Сувдан замбала ХХК-д шилжүүлэхдээ худалдан авалтын и баримтыг аваагүй гүйлгээ хийсэн байна.
2. Тайлант хугацааны бараа ажил үйлчилгээний зардлын төлөвлөгөө нь төсвийн гүйцэтгэлийн тайлангаас 25.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн.

Аудитаар нийт 1,490.0 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 1,490.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоов.

### 5.1 Төлбөрийн акт

5.1.1 Тайлант хугацаанд 890.0 мянган төгрөгөөр өргөмжлөл, тууз, дурсгалын эд зүйлс, мөн дартс зэрэг зүйлсийг худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 дах "Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэсэн заалтыг зөрчиж байна.

*Шийдвэрлэсэн нь*: Холбогдох буруутай албан тушаалтнаар 890.0 мянган төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн актыг тогтоов.

5.1.2 Тайлант хугацааны 1-6 саруудад хүнсний тайлангаар 600.0 мянган төгрөгийн хоолны менюгүй бичээгүй хүнсийг зарлага болгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Төсвийн тухай хуулийн дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтыг тус тус зөрчиж байна.

*Шийдвэрлэсэн нь*: Холбогдох буруутай албан тушаалтнаар 600.0 мянган төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн актыг тогтоов.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл** /мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайланд буруу бүртгэсэн | 1 | 25.0 | | | 1 | 25.0 | 1 | 25.0 | | |
| Санхүүгийн тайланд бүртгээгүй | 1 | 7,045.2 | 1 | 7,045.2 | | | 1 | 7,045.2 | | |
| Дүн | **2** | **7,070.2** | 1 | 7,045.2 | **1** | 25.0 | **2** | **7,070.2** | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тайлант хугацааны 1-6 саруудад хүнсний тайлангаар 600.0 мянган төгрөгийн хоолны менюг | 1 | 600.0 | 1 | 600.0 | | | | |

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| бичээгүй хүнсийг зарлага болгосон зөрчил илэрлээ. | | | | | | | | |
| **Нийт дүн** | **1** | **600.0** | **1** | **600.0** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой зөрчил | | | | | | | | |
| Тайлант хугацаанд 890.0 мянган төгрөгөөр өргөмжлөл, тууз, дурсгалын эд зүйлс, мөн дартс зэрэг зүйлсийг худалдан авсан байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 дах заалтыг зөрчиж байна. | 1 | 890.0 | 1 | 890.0 | | | | |
| Дүн | **1** | **890.0** | **1** | **890.0** | | | | |

------------oOo-------------